- 5.10. Суулгац тарих ажилд талууд хамтран оролцоно.

Зургаа. Талуудын хариуцлага

- 6.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа албадлага шаардлагагүйгээр зохих ёсоор хугацаанд нь биелүүлэхийг эрмэлзэнэ.
- 6.2. Талууд гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд буруутай тал нөгөө талдаа хугацаа хэтрүүлсэн хонго тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувиар алданги төлнө.
- 6.3. Аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан нөгөө талд хохирол учирсан тохиолдолд учирсан хохирлыг буруутай тал харууцна. Хохирол нь акт, дүгнэлт зэрэг нотлох баримтаар нотлогдсон байвал зохих бөгөөд хэмжээ нь бодит хохиролд нийцсэн байна.
- 6.4. Гэрээний хугацаа дуусгавар болсон нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүй талыг үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

- 6.5. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй буруутай тал Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээний аль нэг тал гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал /*төхийгдэл*: газар хөдлөлт, уур, салт туйнээр, дахлын нүүрлэг, хар салхи, хавдарын өвчний тархалт (Covid-19) болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажлаа хяалт, төрийн шийдвэр, оролцоо, хэргийн хяналтгалт, хорио цээрийн дэглэм гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /*ахдагч*, *торгууль*/ чөлөөлөгдөх, үүргийг тохирсон хугацаагаар хойшлуулах үндэслэл болох бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын талаар харилцан зөвшилцөлд хүрнэ.
- 7.2. Төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, мэдэгдэл нь давагдашгүй хүчин зүйл байсан, мөн үргэлжилсэн хугацааны хангалттай нотолгоо болно.

Найм. Маргаан шийдвэрлэх

- 8.1. Энэхүү гэрээний улмаас үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.2. Талууд маргаан шийдвэрлэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.

Ес. Гэрээ цуцлах

- 9.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг цуцалж болно.
- 9.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд нэг тал нь энэхүү гэрээг дангаар цуцлах талаар нөгөө талд бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Бичгээр мэдэгдэл хүргүүлснээс хойш хуандийн 7 (долоо) хоног өнгөрсөний дараа нэг талын санаачилгаар гэрээг цуцлах эрх үүснэ.
- 9.3. Гэрээг харилцан тохиролцож цуцалсан тохиолдолд энэхүү гэрээний 8.2 дахь хэсэгт хмаарахгүй бөгөөд хохирол, зардлыг гэм буруутай тал хариуцна.

Арав. Бусад

- 10.1. Талууд энэхүү гэрээг Монгол хэлээр 2 (хоёр) эх хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 10.2. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээний үүрэг биелэгдсэн, талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд дуусгавар болно.
- 10.3. Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэнэ.
- 10.4. Талууд гэрээнд заасан эрх, үүргээ нөгөө талын бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 10.5. Талууд энэхүү гэрээний дагуу олж мэдсэн, харилцан солилцсон баримт бичиг, мэдээллийн нууцлалыг хугацаагүйгээр чанд хадгалах үүрэгтэй эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд нөгөө талын зөвшөөрөлгүйгээр ашиг хонжоо олох зорилгоор ашиглах, гуравдагч талд задруулахыг хориглоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧ ТАЛ:

БОХАБЗАА-НЫ ӨС-НЫ АХЛАХ ИНЖЕНЕР


_____ А.КАЛЕМШАРИВ

ХУДАЛДАН АВАХ АЖИРААГААНЫ
ХЭЛТСИЙН ХЭРГЭЖИЛТЭН


_____ М.АНХБААТАР

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ:

ЗАХИРАЛ



С.БАТБОЛД

0000037



МОНГОЛ УЛС

ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭ

2013 оны 05 сарын 06 өдөр

Улаанбаатар хот

Серийн ДАА

Дугаар 2013/О-20

ДАРХАН-УУЛ

(аймаг, нийслэлийн)

ДАРХАН

(сум, дүүрэг)-ийн

8000573

тоот регистрийн дугаартай

"МӨНХ НОГООН УРГАМАЛ" ХХК

(аж ахуйн нэгж, байгууллага)

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 20 13 оны 05 сарын 01 өдрийн

А-134

тоот тушаалыг үндэсэн

Ойжуулалт, мод үржүүлэх, ойг нөхөн сэргээх

чилгээгээр үйл ижиллэгаа явуулах эрхийг 7 гурван жилийн хугацаагаар олгоно.

БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙД



С.ОЮУН

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батсан.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2009.03.20
Бүртгэсэн өдөр, сар, өдөр

9071001032
Улсын бүртгэлийн дугаар

8000573
Регистрийн дугаар

Мөхөөгдсөн уртшил

Нэгдүгээр үйлчилгээ ТББ

Хуулийн этгээдийн нэр, хэрэгшлэлийн тэмдэг

Дүрэм

Хүрээ байгуулалтын баримт бичиг

Шийдвэр
Хуулийн этгээдийн нэр

01
Дүрэм

2008.03.02
өдөр, сар, өдөр

020000
Ард

Байгаль аюулгүйн тэнцвэрт байдал, хангах, мод бүтээгүүртэд эрх зүйлс, нөхөн сэргээлт
хүндэтгэн дэмжих

Гүйцэтгэх зорилго үйл ажиллагааны чиглэл

Ард

Гүйцэтгэх зорилго үйл ажиллагааны чиглэл

Хугацаагүй
Хугацаа

1

4,000.0

Аргаар үйлдэх өсөл

Ардийн зориулалтын хэмжээ, мөнгөн тэмдэгт

Дархан-Уул, Дархан сум, 4-р баг, 1-А - 10, утас1994037711, утас2-900950278, факс

Хуулийн этгээдийн нэрийн өсөл



Мод тарисан ажлыг хүлээн авсан акт:



“Тэрбум мод”-ны хүрээнд 2022 онд Гангийн үйлдвэрт
7400 мод тарисан ажлыг хүлээн авсан тухай акт №01

2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

№	Асуулт	Хариулт
1	Байршил: Аймаг, сум, дүүрэг, баг, хороо Газрын нэр:	Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг, Үйлдвэрийн район “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК-ийн байрнаас төв засмал замруу явлаг технологийн замын 2 талд
2	Аж ахуй нэгжийн нэр: Хаяг: Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: Регистр:	“Батбадрах дэлгэр” ХХК Дархан-Уул аймаг, Дархан сум, 4-р баг, Өргөө баг, 21-р хороолол – 1а байр 16 тоот 000027685 4260813
3	Улсын бүртгэлийн дугаар:	1911015132
4	Мод тарих, хүлээлгэн өгсөн албан тушаалтан: Овог нэр:	“Батбадрах дэлгэр” ХХК-ийн захирал С.Баттөмөр
Тарисан модны хэмжээ, чанар, үр дүн		
5	Модны тоо:	7400 ширхэг
6	Модны төрөл:	Хайлаас
7	Зардал:	11,100,000 тограт
8	Нэмэлт	2-3 настай суулгац

Мод тарисан тухай


ДУГНЭЛТ:

1. “Батбадрах дэлгэр” ХХК, “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК-ны хооронд 2022.10.21-ний өдөр хийсэн “Ажил гүйцэтгэх” гэрээний дагуу 7400ш хайлаас мод тарисан.
2. 2023 оны 06 сард гэрээний гүйцэтгэлийн дагуу дахин тооллого хийж ургалтгүй болсон суулгацны тосгоор нөхөн тарих ажлыг “Батбадрах дэлгэр” ХХК хариуцна.
3. “Батбадрах дэлгэр” ХХК нь хайлаас модны суулгац тарих ажлыг хангалттай хийж гүйцэтгэсэн гэж дүгнэлээ.
4. Дарханы Төмөрлөгийн Үйлдвэрийн хэсэгт 7400ш хайлаас тарих ажлыг “Батбадрах дэлгэр” ХХК-наас 7 хүн, “Мөнх Ногоон Ургамал” НҮТББ-аас 7 хүн хамтарч гүйцэтгэсэн ба Төмөртэй уурхайн 9 ажилтан мод тарих ажилд туслан оролцов. Нийт 23 хүн, трактор оролцсон.
5. Мод тарих ажил гүйцэтгэсэн зургийг хавсаргав.


ЗАХИАЛАГЧИЙН ТАЛААС ХҮЛЭЭН ЗӨВСӨН:

ХААХ-ийн дарга:  М.Анхбаатар

БОХАБЭАА-ны дарга:  Н.Батцэнд

БО-ны ахлах инженер:  А.Калемшарив

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

"Батбадрах дэлгэр"
ХХК-ийн захирал:  С.Баттөмөр
С.Баттөмөр

5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар
Байхгүй	-	-	-	Төмөртолгойн уурхай нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р багийн нутаг дэвсгэрт харьяалагдах бөгөөд “Ашигт малтмалын тухай” хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Ашигт малтмал, Газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар 2007 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 424.09 га талбайд ашигт малмал ашиглах МҮ-010738 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий газар үйл ажиллагааг явуулж байна. Баяжуулах үйлдвэрийн зориулалтаар Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг даргын 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 83 тоот шийдвэрээр сунгагдсан үйлдвэрлэлийн зориулалт бүхий 70 га талбайг 15 жилийн хугацаатай эзэмшиж байна. Төсөл хэрэгжүүлэх хугацаанд болон цаашид ойролцоох аж ахуйн нэгж, иргэдэд нүүлгэн шилжүүлэх шаардлага өгөөгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авахгүй.

6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар
Байхгүй	-	-	-	Төмөртолгойн уурхайд Улаанбаатар дээд сургуулийн Археологийн танхимаар түүх, палентлоги, археологийн судалгаа хийлгэсэн ба уурхайн ажилд өртөх түүх соёлын өвд хамаарах олдвор байхгүй гэсэн дүгнэлт гарсан. Гэвч уурхайн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвд хамаарах олдвор олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг зогсоож, мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж хамтран ажиллана.

7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Д/д	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт	Зардал, төг	Тайлбар
1	Уурхайн хөрсний нуралт	Хөрсний эвдрэл гэмтлийн талаарх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэгийг байнга хийх	Тогтмол хэрэгжсэн	Дотоод зардал	Өдөр тутмын тойрох үзлэгээр хяналт тавьж ажилладаг
2	Техникийн аваар	Техник тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны заавар дүрмийг чанд баримтлах	Тогтмол хэрэгжсэн	Дотоод зардал	ХАБЭА-н нэгжтэй байнга хамтран ажиллаж ирсэн
3	Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх	Тогтмол хэрэгжсэн	Дотоод зардал	ХАБЭА-н нэгжтэй байнга хамтран ажиллаж ирсэн
4	Үер	Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний дагуу болон гамшгийн төлөвлөгөөний дагуу ажиллах	Тогтмол хэрэгжсэн	Дотоод зардал	Шар усны үерт автаж Зулзагын голын гүүр нурж унасныг уурхайн нөөц бололцоог ашиглан засварласан
5	Газар хөдлөлт	Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний дагуу болон гамшгийн төлөвлөгөөний дагуу ажиллах	Тогтмол хэрэгжсэн	Дотоод зардал	Газар хөдлөлтөөс үүдэлтэй гамшиг болоогүй
6	Гал түймэр	Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний дагуу болон гамшгийн төлөвлөгөөний дагуу ажиллах	Тогтмол хэрэгжсэн	Дотоод зардал	Гал унтраах багаж буюу гал унтраагуурыг 5 кг савлагаатайг 150 ширхэг, 9 кг савлагаатайг 50 орчим ширхэгийг нийлүүлсэн. Төмөр замын 19-р гарамд тог цахилгааны монтаж хийн, галын самбар, галын сарааныг сольж, иж бүрдлийг бүрдүүлж өгсөн.
7	Хүн малын гоц халдварт өвчин	Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний дагуу болон гамшгийн төлөвлөгөөний дагуу ажиллах	Тогтмол хэрэгжсэн	Дотоод зардал	Халдварт шүлхий өвчний үед төмөр замын 19-р гарам болон уурхайн нэвтрэх 5-р постон дээр ариутгалын байр, ариутгалын бодис, хүн хүчийг гарган ажиллуулсан. Орсон гарсан техник бүрт ариутгал хийж ажилласан.

8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Дд	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хүрээ	Хэрэгжилт	Зардал, төг	Тайлбар
1	Ахуйн хог хаягдал	Ахуйн хог хаягдлыг орон нутгийн нийтийн аж ахуйн газартай гэрээ байгуулан ажиллаж, нийлүүлэх	Уурхайн бүх ахуйн хог хаягдал	Тогтмол хэрэгжиж байна	1,348,00	Хог хаягдлыг тээвэрлэн зайлуулах гэрээ байгуулж, хог хаягдлыг тогтмол тээвэрлүүлдэг
2	Бүх хог хаягдал	Хог хаягдлыг ангилан ялгах цэг байгуулж, дахин боловсруулагдах хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад нийлүүлэх	Уурхайн бүх хог хаягдал	Тогтмол хэрэгжиж байна	Дотоод зардал	Хог хаягдлыг ангилан, түр хадгалах цэгт хадгалан, мэргэжлийн байгууллагад нийлүүлдэг
3	Уурхайн технологийн хог хаягдал	Технологийн хог хаягдлыг хог боловсруулах мэргэжлийн байгууллагад нийлүүлэх	Уурхайн бүх технологийн хог хаягдал	Тогтмол хэрэгжиж байна	-	Технологийн хог хаягдал нийлүүлэх шаардлага гараагүй
4	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг ангилан хадгалах, мэргэжлийн байгууллагаар зайлуулах,	Уурхайн аюултай хог хаягдал	Тогтмол хэрэгжиж байна	-	“ЮТО” ХХК-тай гэрээ байгуулж, устгуулсан
5		Аюултай хог хаягдлыг төрөл дугаараар чанд бүртгэж, тайлан мэдээг тогтмол явуулж байх	Уурхайн аюултай хог хаягдал	Тогтмол хэрэгжиж байна	Дотоод зардал	Аюултай хог хаягдлыг үүсгэгчийн бүртгэлийн дугаар авч, төрлөөр нь тогтмол бүртгэдэг
6	Эмнэлгийн хог хаягдал	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлэх	Уурхайн эмнэлгийн хог хаягдал	Тогтмол хэрэгжиж байна	120,000	Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан тогтмол өгч устгуулдаг
Нийт					1,468,000	



Зураг 16 Хуучин пошиг, савуудыг дахин ашиглаж хогийн сав хийсэн ба эмх цэгцгийг сайжруулсан байдал



Зураг 17 Хаягдал дугуйг консервацын талбайд хашлага болгон дахин ашигласан байдал

Дахин ашиглах боломжтой ус, ундааны хуванцар савнуудыг тусад нь ялгаж түр хадгалан хуванцар боловсруулах үйлдвэрт нийлүүдэг.



Зураг 18 Хуванцар савыг ангилан хаясан байдал



Зураг 19 Уурхайн ахуйн хог хаягдлыг Хонгор сумтай хийсэн гэрээний дагуу ачуулж буй байдал

Эмнэлгийн аюултай хог хаягдлын тусгай зориулалтын саванд түр хадгалан мэргэжлийн байгууллагад өгч устгуулдаг.



Зураг 20 Эмнэлгийн хог хаягдал түр хадгалах сав

Төлбөрийн даалгавар 493

2022 оны 08 сарын 04 өдөр

Маягт N: TC-7

Санхүү, Эдийн засгийн сайдын 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 182 тоот тушаалаар батлав.

Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК		Данс	Дүн
Төрийн банк	банк	Дебет 140801859735	76,000.00
Да, Да Хог хаягдлын хураамж		Кредит	
Төрийн сан	банк	100190100947	
Дүн (тоогоор)	76,000.00		...хоногийн...хувийн...торгууль бүгд.....төг.....мөн
Дүн (үсгээр)	Далан зургаан мянган төгрөг		
Эзэн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн огноо			Дүн (торгуулийн хамт)
2022 оны 08 сарын 04 өдөр			
Зориулалт (Барааны болон ажил үйлчилгээний нэр, дагалдах баримтын дугаар)			Гүйлгээний утга
Хог хаягдлын төлбөр			Төлбөрийн зориулалт
Банкинд гүйлгээ хийсэн 2022 оны 08 сарын 04 өдөр			Төлөх хугацаа
Тэмдэг, гарын үсэг			Төлбөрийн ээлж

Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК		Данс	Дүн
Төрийн банк	банк	Дебет 140801859735	152,000.00
Да, Да Хог хаягдлын хураамж		Кредит	
Төрийн сан	банк	100190100947	
Дүн (тоогоор)	152,000.00		...хоногийн...хувийн...торгууль бүгд.....төг.....мөн
Дүн (үсгээр)	Нэг зуун тавин хоёр мянган төгрөг		
Эзэн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн огноо			Дүн (торгуулийн хамт)
2022 оны 09 сарын 05 өдөр			
Зориулалт (Барааны болон ажил үйлчилгээний нэр, дагалдах баримтын дугаар)			Гүйлгээний утга
Хог хаягдлын хураамж			Төлбөрийн зориулалт
Банкинд гүйлгээ хийсэн 2022 оны 09 сарын 05 өдөр			Төлөх хугацаа
Тэмдэг, гарын үсэг			Төлбөрийн ээлж

“ЮТО” ХХК-тай хийсэн “Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх” гэрээ:



ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 10-р сарын 12-ны өдөр

№

Улаанбаатар хот.

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 5003032 тоот регистрийн дугаартай “ЮТО” ХХК-г төлөөлж Гүйцэтгэх захирал Ө.Батсайхан, нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 6298141 тоот регистрийн дугаартай “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК -г төлөөлж Ерөнхий захирал М.Отгонбаяр нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний Монгол улсын Иргэний хуулийн 243-264 дүгээр зүйл заалтыг баримтлан энэхүү техникийн ажилласан тос бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК (цаашид ХУДАЛДАН АВАГЧ гэх) болон “ЮТО” ХХК (цаашид НИЙЛҮҮЛЭГЧ гэх) нарын гэрээнд заасан хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарах техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /цаашид “АХХ” гэх/-г цуглуулах, тээвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, түүнд тохирох үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр Үйлчилгээтэй холбоотой хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.
- 1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зураагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Гэрээ нь “ЮТО” ХХК болон “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК -ийн төлөөлөлүүд гарын үсэг зурснаар хугацаагүй хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 2.2 Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Иргэний хуульд зааснаар гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.
- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар харилцан мэдэгдэл ирүүлээгүй тохиолдолд гэрээ анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 2.4 Энэхүү гэрээний нөхцөл, болзол, заалтаас татгалзан дуусгавар болгох тухай санал, шалтгааныг талууд зөвхөн албан бичгээр тайлбарлан гаргана.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Талууд бие биенээсээ энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.
- 3.2 Талууд аюултай хог хаягдал /цаашид АХХ гэх/-г юүлэх, зөөх, тээвэрлэх, машинд ачиж буулгах зэрэг АХХ-г хөдөлгөх тухай бүрт хариуцлагатай байж, ажлын болон агуулахын талбай, газар шороо, байгаль орчинг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 3.3 **“Нийлүүлэгч”** нь АХХ-н тээвэрлэлт, аюулгүй ажиллагаа, ачилтын асуудалд үүсэх эрсдлийг хариуцаж, бэлтгэн нийлүүлэгчийн талбайгаас бүрэн зориулалтын техникээр тээвэрлэн худалдан авагчийн үйлдвэрийн байр луу тээвэрлэх үүрэгтэй. **“Нийлүүлэгч”** нь ачих, тээвэрлэх үедээ хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллана.
- 3.4 **“Худалдан авагч”** бэлтгэн нийлүүлэгчээс тээвэрлэгдэн ирсэн энэхүү гэрээний 3.3 заалтын дагуух АХХ-ыг тохирох эсэхийг өөрийн лабораторт судалж, шинжилсний үндсэн дээр түүхий эд болгон ашиглах эрхтэй.
- 3.5 **“Нийлүүлэгч”-ийн** нийлүүлсэн техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдлыг хүлээн авснаар бүх эрсдэл, хариуцлага **“Худалдан авагч”**-д шилжинэ. Хүлээн авсан аюултай хог хаягдлыг **“Худалдан авагч”** нь хэрхэн ашиглах, ашигласан нь **“Нийлүүлэгч”**-д үл хамаарна.
- 3.6 **“Нийлүүлэгч”** болон худалдан авагч нь сард нийлүүлэх АХХ-ын хэмжээг 2 талаас тохиролцох ба гэрээний хавсралтаар баталгаажуулж явна. Мөн нийлүүлэгч болон худалдан авагч талууд тус бүрийн үйл ажиллагаанаас хамаарч АХХ-ын хэмжээ, хугацаа өөрчлөгдөх болвол харилцан мэдээллээ солилцож, хамтран ажиллана.

ДӨРӨВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ, ХУГАЦАА

- 4.1 **“Нийлүүлэгч”-ийн** нийлүүлж буй шаардлага хангасан ашигласан тос тосолгооны материалыг үнэгүй нийлүүлнэ.
- 4.2 **“Нийлүүлэгч”-ийн** тээврийн зардлыг бүрэн /Сэлэнгэ аймгийн Ерөө болон Хонгор суманд байрлах уурхайнуудас Улаанбаатар хот хүртлэх/ хариуцна.
- 4.3 АХХ-н нийлүүлэлтийн тооцоог нийлж, төлбөрийг **“Худалдан авагчийн”-ийн ХХБанк -ны 459015176** тоот төгрөгийн дансанд нэхэмжлэлийн дагуу АХХ-г ажлын 3 хоногийн дотор шилжүүлнэ.
- 4.4 **“Худалдан авагч”** нь гэрээнд заасан төлбөрөө төлөөгүй бол **“Нийлүүлэгч”** нь дараагийн нийлүүлэлтийг тухайн хойшлогдсон хугацаагаар хойшлуулж болно.
- 4.5 **“Худалдан авагч”** нь гэрээний төлбөрийг цаг тухай бүр гүйцэтгэх үүрэгтэй ба ийнхүү гүйцэтгээгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0,05 хувьтай тэнцэх алданги оногдуулна.
- 4.6 Нийлүүлэгчийн бэлтгэн нийлүүлж байгаа барааны үнийн өөрчлөлтийг хоёр талаас харилцан тохиролцож гэрээнд үнийн өөрчлөлт оруулж болно

ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 5.1 Ямар ч тохиолдолд аль нэг тал түүний хяналтаас гарсан аливаа шалтгаан, нөхцөл байдлын улмаас шууд эсхүл шууд бус байдлаар, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.
- 5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал, ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдохгүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр,

тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.

- 5.3 Дээрхээс шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Энэхүү гэрээнд заасан хэлцлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан гэрээнд тусгагдсан болон гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөр өөрсдөө хариуцна.

ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.
- 7.2 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
“ЮТО” ХХК-ны


ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-ны

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР



Г. БАТЦОГТ /

Байгал орчны инженер



М.ӨӨЛҮН /

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

Хаяг: Монгол улс,
Улаанбаатар хот, БЗД, 26-р хороо, 404-
103 тоот
Утас: 99097688, 99090313

Хаяг: Монгол улс,
Дархан-Уул аймаг, Дархан сум, 2-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХК-ийн
төв оффисын 304 тоот
Утас: 99279734

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор баталсан



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2005.06.20

/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011001033

/Улсын бүртгэлийн дугаар/

5003032

/Регистрийн дугаар/

ЮТО

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тогтоол

/шийдвэрийн нэр/

01

/дугаар/

2005.06.17

он, сар, өдөр

511000

/код/

Гадасд худалдаа

/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй

хугацаа

2


/Гишүүдийн тоо/

1,500.0

/Өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Сонгинохайрхан, 19-р хороо, Геологийн 48-н айл, 2 - 48 тоот, утас1:95155891, утас2:344416, факс:

/хуулийн этгээдийн а:бан ёсны хаяг/



Улсын бүртгэлийн алба

/Бүртгэсэн байгууллагын нэр/

УХА0175

Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан, үзэмдэг
УБ Хан-Уул Т/Т	Төгрөгийн	2603010432	Ц.Цэнддорж

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тэмдэг
1	<i>СХД Монтбарак хэмээх тооллогог хайрцуув</i>	<i>2007.05.28</i>	<i>Д.Т.Онов</i>
2	Дүрмийн сан 0-р хасагдаж 1500.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2008.01.09	Б.Авирмэд
3	Өлзийсайхан овогтой Хүдрээ -г Захирал -р томилсныг бүртгэв.	2008.01.09	Б.Авирмэд
4	Дүрмийн сан 0-р хасагдаж 1500.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2011.05.18	Ц.Билэсүх
5	Өөрийн хөрөнгийг хэмжээ 251500.0 мян.төг-р нэмээдэж нийт 253000.0 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2011.11.02	М.Заябат
5	Худалдаа хөгжлийн банк банкны 459015176 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Худалдаа хөгжлийн банк банкны 459015177 тоот валютын дансыг бүртгэв.	2013.06.28	У.Давгаасүрэн

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

Аюултай хог хаягдал болох ашигласан тос, маслыг "ЮТО" ХХК-д өгч устгуулсан акт:

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК

Төмөртолгой хүдрийн уурхай

Машин механизмын сэлбэг материал шилжүүлэх АКТ №2022.06.23

1	Цех хэсэг, хэлтэс:	Төмөртолгой хүдрийн уурхай
2	Хүлээж авах цех, хэлтэс:	"ЮТО"-ХХК
3	Хүлээлцсэн огноо:	2022.06.23
4	Тээвэрлэгчийн улсын дугаар:	13-84 УБА
6	Жолоочийн нэр:	Болд

Д/д	Хөрөнгийн нэр марк	Эдийн дугаар	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Масло	*	литр	18000	Ажилласан

Шилжүүлэх үндэслэл:

ТГХУурхайн ажилласан тос масло ахин ашиглах боломжгүй аюултай хог хаягдал тул байгал орчины менежментийн төлөвлөгөөний дагуу мэргэжилийн эрх бүхий "ЮТО"-ХХК-д устгалд оруулахаар хүлээлгэн өглөө.

Хөрөнгийн байдлын тодорхойлолт:

Хуучин

	Албан тушаал	Овог нэр	Гарын үсэг
Зөвшөөрсөн:	Уурхайн менежер	Р.Дамбаравжаа	
Хянасан:	ТҮЗА механик	А.Идэржавхлан	
Хянасан:	ТГХУ-диспетчер	Б.Лхагвадулам	
Хянасан:	Харуулын ахлах	Дашдорж	
Хүлээлгэн өгсөн:	ТГХУ-ЭХДХөтлөгч	Б.Одонтунгалаг	
Хүлээн авсан:	Тээвэрлэгч	Болд	



Зураг 21 Ашигласан тос маслыг “ЮТО” ХХК-д өгч буй байдал

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Д/д	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжилт	Зардал, төг	Тайлбар
Агаар					
1	PM10, PM2.5	Уурхайн тоосжилт хамгийн ихтэй цэгүүд болон ажилчдын байрны дотоод орчин	Тогтмол хэрэгжиж байна	184,800	Өрөмдлөгийн хэсгийн орчим, авто засварын бааз, баяжуулах хэсгийн орчимоос 03, 05, 11 саруудад УЦУОШТ-р шинжилгээ хийлгэсэн
	NO2, SO2, CO, нийт тоос тодорхойлох				
	Агаар дахь хүнд элементүүд /14 элемент/				
Хөрс					
2	Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд	Уурхайн карьер болон ангилан ялгах талбай болон ажилчдын байрны ойролцоо	Тогтмол хэрэгжиж байна	184,800	Баяжуулах үйлдвэрийн орчин, Шимт овоолго, ШТС-н орчимоос 03,11 саруудад УЦУОШТөвөөр шинжилгээ хийлгэсэн
	Хүнд элементийн шинжилгээ /8 элемент/				
Ус					
3	Ерөнхий хими	Худаг	Тогтмол хэрэгжиж байна	184,800	Уурхайн шүүрлийн ус, гүний худаг, ундны уснаас 03, 10 саруудад УЦУОШТ, Ус суваг ХК-р шинжилгээ хийлгэсэн
	Хүнд элементийн шинжилгээ				
	Усны түвшин хэмжилт				
Нийт				554,400	

Жич: 2022 оны 11 сард хөрс, агаарын шинжилгээний дээж Дархан-Уул аймгийн УЦУОШТөвийн мэргэжилтэнгүүд ирж авсан, хариу нь гараагүй байна.

БАТЛАВ.
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УЦУОШТ-ИЙН ДАРГА
.....
/С.АЛТАНДОЛГИЙН/

БАТЛАВ.
"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН
ҮЙЛДВЭР" ХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИАЛАГЧ
.....
/М.ОТГОНБАЯР/

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ
№ 01/2020

2020 оны 4 дүгээр сарын 28

Дархан-Уул аймаг

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Агаарын тухай хуулийг хэрэгжүүлэхэд УЦУОШТ нь Дархан-Уул аймаг дахь агаарын чанарын мэргэжлийн салбар албаны үүргийг гүйцэтгэдэг.

Агаарын тухай хуулийн 9.1.3; 9.1.4 заасны дагуу агаар бохирдуулагч эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн байгууллагаар байгаль орчны бохирдлын хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Нэг талаас: Дархан-Уул аймаг дахь УЦУОШТ-ийн УОШХ-ийн дарга М.Алимаа /цаашид гүйцэтгэгч гэх/ Нөгөө талаас: "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийг төлөөлж Байгаль орчны инженер М.Зоригтхүү /цаашид захиалагч гэх/ нар нь "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн үйлдвэрлэлийн орчны байгаль, орчны хяналт шинжилгээний ажлыг улирал тутамд гүйцэтгэгч талаар хийлгэхээр энэхүү гэрээг байгуулав. Энэхүү гэрээ нь 4 жилийн хугацаанд хүчинтэй болно.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Шинжилгээний ажлын заавар, удирдамжийн дагуу явагдаж байгааг хяналт тавих, шаардах
- 2.2. Тухайн үеийн шинжилгээний ажлын сорьц авах үед унаагаар хангах
- 2.3. Шинжилгээний ажлын эцэст үр дүнг шалгаж хүлээн авах
- 2.4. Гэрээт шинжилгээний ажлын төлбөрийг хугацаанд нь төлөх

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 3.1. Захиалагчийн үйлдвэрлэлийн орчны шинжилгээ, судалгааны сорьц, дээжийг авч, чанарыг алдагдуулахгүйгээр лабораторийн шинжилгээнд авчрах
- 3.2. Итгэмжлэгдсэн лабораторийн химийн сорилт, шинжилгээний ажлыг Монгол улсад мөрдөж байгаа MNS, MNS ISO стандарт, аргачлалын дагуу заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэх
- 3.3. Шинжилгээний үр дүнд ямар нэгэн буруу эргэлзээтэй зүйл гарвал түүнийг засах, давтан шинжилгээ хийх асуудлыг хариуцах
- 3.4. Шинжилгээний дүнг сорилтын дүнгийн хуудаст баталгаажуулж ирүүлсэн байх

- 3.5. Гэрээт ажлын төлбөрийг барагдуулахыг шаардах, нэхэмжлэх
- 3.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад хүндэтгэх шалтгаанаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчид нэн даруй мэдэгдэж өөрсдийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авах

Дөрөв. Шинжилгээний ажлын хөтөлбөр

4.1. Агаар орчны бохирдлын хяналт шинжилгээ

Сорьц авах цэг: Үйлдвэрлэлийн бохирдлын эх үүсвэрийн орчинд
/Үйлдвэрийн орчин, баяжуулах цех, Төмөр толгойн уурхай, карьер/

Тодорхойлох үзүүлэлтүүд:

- А. Агаар дахь азотын давхар исэл /NO₂/
Б. Агаар дахь хүхэрлэг хий /SO₂/
В. Агаар дахь PM10, PM2.5, нийт тоосонцрын агууламж
Г. Нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/
Д. Агаар орчны цацрагийн түвшин

4.2. Усны шинжилгээ

Сорьц авах цэг:

- А. Технологийн ус
Б. Хаягдал ус
В. Худгийн ус

Тодорхойлох үзүүлэлтүүд:

Усны химийн шинжилгээний 19 үзүүлэлтээр /хавсралтаар/

4.3. Хөрсний бохирдлын хяналт шинжилгээ

Сорьц авах цэг: Төмөр толгойн уурхай, Шатахуун түгээх станцын орчинд


Тодорхойлох үзүүлэлтүүд: А. Хөрсөн дэх агрохимийн бохирдол
Б. Нефтийн бүтээгдэхүүний бохирдол
В. Хүнд металлын бохирдол

Тав. Төлбөр тооцоо


- 5.1. Шинжилгээний төлбөрийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/164 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Орчны чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, үнэ тариф"-ын дагуу тооцно.
- 5.2. Шинжилгээний ажлын төлбөрийг байгууллагын нэр: Да.УЦУОШТөв, регистр 9023291, Төрийн сан банк 100190013015 тоот дансанд ажлын 10 хоногт төвлөрүүлнэ.
- 5.3. Төлбөрийг барагдуулсны дараа шинжилгээний дүнг албан тоотгоор хүргүүлнэ.
- 5.4. Захиалагч байгууллага регистрийн дугаар 2051303
- 5.5. Захиалагчаас заасан шинжилгээний үзүүлэлтүүдийн тоо, төлбөрийн талаарх тооцоог жил бүрийн эцэст тооцож гүйцэтгэгчийн санхүүтэй 11 дүгээр сарын 05-ны дотор тооцоо нийлж акт үйлдэнэ.

ГЭРЭЭ ХИЙСЭН:


УЦУОШТ-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
УОШХ-ИЙН ДАРГА

 М.АЛИМАА
УТАС: 99378302

ДАРХАН ТӨМӨРЛӨГИЙН
ҮЙЛДВЭР" ХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ
БО-НЫ МЭРГЭЖИЛТЭН

 М.ЗОРИГТХҮҮ
УТАС: 95956927

НЯГТЛАН БОДӨГЧ

 Э.ДОЛГИОН

10. Аймаг нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

10.1 Хонгор сумын Буурал багийн хогийн цэг булшлах ажил

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р баг буюу Буурал багт байршилтай төвлөрсөн хогийн цэгийн 7 га газрыг булшлах ажлыг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг дуустал нийт 10 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Уг ажилд 2 ээлжээр 6 хүний бүрэлдэхүүнтэй, автогрейдр /CAT/, дугуйт ачигч /LG8128/ техникүүдийг ашиглан оролцсон. 189,862 м² талбайд 56,966 м³ хог хаягдлыг ландшафтын /булшлах/ аргаар булж устгасан.



Зураг 22 Хонгор сумын хогийн цэгт хийсэн хэмжилт



Зураг 23 Ажил гүйцэтгэхийн өмнөх байдал



Зураг 24 Ажил гүйцэтгэсний дараах байдал

ХОНГОР СУМЫН ХОГИЙН ЦЭГ БУЛШЛАХ АЖИЛД ГАРСАН ЗАРДАЛ

2022.05.30

№	Зардлын төрөл	Нийт зардал	Тайлбар
1	Шатахууны зардал	20,365,630	Автоачигч болон автогрейдерийн зарцуулсан түлш-6398 л түлш
2	Элэгдэл зардал	5,137,253	Автоачигчийн 10 хоногийн элэгдэл, Автогрейдер 4 хоногийн элэгдэл
3	Хөдөлмөрийн зардал	5,803,135	Автоачигчийн оператор 2 ээлжээр 10 хоног, ээлжийн мастер 2 ээлжээр 10 хоног, Автогрейдер оператор 2 ээлжээр 4 хоног
Нийт		31,306,018	

10.2 Нийгмийн хариуцлагын хүрээнд Хонгор сумтай хамтран ажиллах гэрээ байгуулах

Нийгмийн хариуцлагын хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хонгор сумтай “Хамтран ажиллах” гэрээнд тусгагдсан ажлын гүйцэтгэл 83.3 хувьтай явж байна.



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 он 10 сарын 17 өдөр

№ _____

Дархан-Уул аймаг

Энэхүү гэрээг нэг талзас "Дарханы төмөрлогийн үйлдвэр" ТӨХК /РД:2051303/-ийг төлөөлж Олон нийттэй харилцах албаны дарга Б.Ганбаяр (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх), нөгөө талаас Дархан-Уул аймаг, Хонгор сумын Засаг Даргын Тамгын Газрын дарга Ч.Мөнхтуяа (цаашид "Засаг дарга" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) байгуулав.

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээ нь Дархан-Уул аймаг Хонгор сумын нутагт ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх.

Хоёр: Гэрээний хугацаа

2.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаас хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.

Гурав: Засаг даргын эрх, үүрэг

3.1 Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

3.2 Засаг дарга нь төлөвлөгөөний дагуу ажлуудын гүйцэтгэлд хяналт тавих, талуудын хамтарсан комисст гишүүдийг томилж ажиллуулах, зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

3.3 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдад тогтмол мэдээлэл өгч, саналыг авах;

3.4 Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж аймаг, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдад мэдээлэх,

3.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн заргасан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдад хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

3.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтад хяналт тавих;

3.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариу өгөх;

4.8 Тухайн жилийн эцэст гэрээ дүгнэсэн акт ирүүлэх

Дөрөв. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

4.1 Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

4.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод хэлбэрээр нийтэд зарлах;

4.3 Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

4.4 Нийт ажлын байрны 15-иас доошгүй жувд тухайн орон нутгийн иргэдийг зохих төвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;

4.5 Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;

4.6 Хэрэгжүүлж байгаа төсөл, өргө хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум)-ын иргэдэд тогтмол мэдээлэл өгч байх;

4.7 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд давуу эрх олгох;

4.8 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

4.9 Гамшгийн үед сайн дурын үздсэн дээр орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

4.10 Тусгай зөвшөөрөл эзэмшигч "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК нь жил бүр 50-оос доошгүй ахмадад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байлах;

4.11 ЗДТГ-ын тохижилт үйлчилгээний хэсэгт хөгжөөрийн зориулалтын авто машин нийлүүлэх /ЗДТГ-ын санал болгосныг харилцан тохиролцож/

4.12 Байгаль орчны эохистой түвшинг хадгалах хүрээнд Хонгор сумын нутаг дэвсгэр дэх цэвэр усны нөөц, эх үүсвэр болох булгийг хашаажуулж тохижуулах /ЗДТГ-тай зөвшилцсөнөөр булгийг сонгох/

4.13 Төмөр толгойн уурхайгаас тус сумын 2 дугаар багийн нутаг 42 дугаар тооч хүртэл 12 км зайд цахилгаан дамжуулах агаарын шугам татахтай холбогдуулан багийн төвийн гадна цөхийн эрчим хүчийг төмөр толгойн уурхайн бив-н шугамаас тэжээгдэх зөвшөөрөл олгох.

4.14 Гэрээний хугацаа дуусахад тайлан боловруулж сумын Засаг Даргын Тамгын Газарт хүргүүлэх.

Тав. Гэрээний хэрэгжилт

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаарх мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг тагуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сум /дүүргийн/ олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дад зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Гэрээний хариуцлага

6.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь Компани хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

6.3 Гэрээний хугацаа дуусахад 2 талын хамтарсан комисс ажиллан гэрээг дүгнэж акт үйлдэнэ.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1 Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцсонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1 Гэрээ талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

8.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө аль нэг талын санаачлагаар дуусгавар болгож болно.

8.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4 Гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэн, талууд нэг нэг хувийг өөртөө хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ХОНГОР СУМ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

Хонгор сумын ЗДТГ-ын дарга:

Ч.Мөнхтуяа

БОХУБайцаагч

Б.Төмөрхуяг



**"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН
ҮЙЛДВЭР" ТӨХК-ийг төлөөлж:**

ХАОНХА-ны

дарга:

Б.Ганбаяр

БОХАБЭАА-ны даргын

үүргийг хавсран

гүйцэтгэгч:

М.Даваахүү

ГУУХ-ийн

дарга:

Г.Хяшигбаяр

ЭЗТХ-ийн

дарга:

Л.Моломкамц

ХХ-ийн

дарга:

Н.Батбаяр

Хавсаргалт 1. "ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ТӨХК БОЛОН
ХОНГОР СУМЫН 2022 ОНЫ ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨӨЛӨГӨӨ

№	Үндсэн чиглэл	Хийгдэх ажлууд	Гүйцэтгэгч	Төсөл /сая. ₮/	Хугацаа
1	Байгаль орчныг хамгаалгах чиглэлээр	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Дархан-Уул аймгийн Хүдэр сумын нутагт 10,400 ш мод тарих, ургуулах ажлыг зохион байгуулна.	БО-ны инженер, Төмөргэйн уурхай, Хонгор сумын БОХУ-ын байцаагч	26	2022 оны 10 сар
		Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай сумын БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагч газар дээр нь танигдах	Хонгор сум БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагч	-	2022 оны турш
2	Нийгмийн харилцааны чиглэлээр	Байгаль орчны зохицой түвшинг хэдгээх хүрээнд Хонгор сумын нутаг дэвсгэр дэх цэвэр усны нөөц, эх үүсвэр болжх бүтцийг хангажүүлж тохижуулах /ЗДТГ-тай зөвшилцснөөр бүтцийг сонгох/	Хонгор сум БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагч	5	2022 онд
		Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биежүүлж ажиллана.	БО-ны инженер	-	2022 онд
		Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллах, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод хэлбэрээр нийгэд зарлана.	ХААХ, ГУУХ, Х өнгөр сумын ЗДТГ-аар	-	2022 оны турш
		Хэрэгжүүлэх төсөл, өргө хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулна.	ХААХ, ГУУХ, Хонгор сумын ЗДТГ-аар	-	2022 оны турш
		Борой, амил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд давуу эрх олгоно.	ХААХ, Хонгор сум	-	2022 оны турш
		Жил бүр 30-аас дээшгүй ахмадад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулна.	ХААХ, Хонгор сумын Засаг даргын орлогч	-	2022 онд

		ЭДТТ-ын тохиолт үйлчилгээний хэсэгт хөг төзөрийн зориулалтын авто машин нийлүүлэх /ЭДТТ-ын санал болгосныг харгалзан тохиролцоо/	ХААХ, Хонгор сумын Засаг даргын орлогч	35	2022 онд
3	Онцгой нөхцөл, гамшиг ослын үед хамтран ажиллах	Хонгор суманд онцгой нөхцөл байдал гамшиг ослын үед "Гамшигээс хамгаалах төлөвлөгөө"-ний дагуу Уурхайгээс шалардлагагай төхөөрөмж, хүн хүч гаргах хамтран ажиллана.	Төмөрлөгтэй уурхай	-	2022 оны турш
4	Дад бүтцийг дэмжих чиглэлээр	Төмөрлөгтэй уурхайгээс Хонгор сумын "Шанэ суурьшлын бүс"-ийн цахилгаан хангамж 12 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг уурхайн 6 км-н шугамаас тэмдэглэд ДСЦТС ХХ-иас гарсан "Техникийн нөхцлийн дагуу хамтран ажиллах, янхий ХХБ-байгууламж доторх тэнцүүлсэн угсралт суурьшуулалт хийх	Цахилгааны алба ХААХ, Хонгор сум	-	2022 онд
5	Бусад	Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгэдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохиц журмын дагуу Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэнэ	ХХ, Хонгор сум	-	2022 онд
Нийт дүн					
49					

Жич: Оны эцэст төлөвлөсөөний хэрэгжилтийгөө өгөхөд 2023 оны хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж ажиллана.

Хонгор сумын Засаг дарга:  Т.Атаршият

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн ЭЗТХ-ийн дарга:  Л.Моломжамц

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн ЗХНХ-ийн дарга:  Ж.Уранчимэг

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн ЦА-ны дарга:  Т.Игтамир

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн БОХАБЗАА-ны БО-ны инженер:  А.Калемшариев

Хонгор сумтай хамтран ажиллах гэрээний дагуу Хонгор сумын нутагт байрлах Могойн голын эхийг тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 25 Булгийн эхийг тохижуулсан байдал

Хонгор сумтай хамтран ажиллах гэрээнд тусгагдсан тохижилт үйлчилгээний хэсэгт хог тээврийн зориулалтын авто машин нийлүүлэх ажлын хүрээнд тусгагдсан 35 сая төгрөгийг шилжүүлсэн.

Хонгор сумын иргэдээс 2022 онд нийт 8 хүнийг ажилд авч хамтран ажиллах гэрээний үүргээ биелүүлэв.

Хүснэгт 5 Хонгор сумаас 2022 онд ажилд орсон ажилчдын жагсаалт

№	Нэгж хэсэг	Албан тушаал	Овог	Нэр	Гэрийн хаяг
1	ТХУ	Автосамосвалын жолооч	Уламбаяр	Жаргалсайхан	Хараа баг, 1-р гудамж, 2 тоот
2	ТҮЗА	Хүнд машин механизм засварчин	Судалхан	Тохтар	1-р баг, Зам хороолол, 1 гудамж, 1 тоот
3	ТҮЗА	Гагнуурчин, засварчин	Цэрэндорж	Мөнх-Очир	1-р баг, Зам хороолол, 12 гудамж, 75 тоот
4	ТҮЗА	Токарчин	Амгаланбаатар	Отгонбаатар	1-р баг, Хараагийн гудамж, 11 гудамж, 84 тоот
5	ТҮЗА	Жолооч, засварчин /сервис/	Булганхангай	Мөнхтулга	Буурал баг, 10 байр, 13 тоот
6	ТҮЗА	Тосолгоочин, засварчин	Цагаанхүү	Жаргалсайхан	1-р баг, Зам хороолол, 7 гудамж, 33 тоот
7	ХАБА	Хамгаалагч	Загдсүрэн	Мөрөн	1-р баг, Атар хороолол, 8 гудамж, 74 тоот
8	ХАОНХА	Хамтын ажиллагаа гадаад харилцааны мэргэжилтэн	Төмөр-Очир	Төрмаа	1-р баг, Буурал баг, 2 гудамж, 207 тоот

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар
1	Үйлдвэрлэлийн зардлаар БО-ны тухай хууль, журам, стандартын биелэлтийг хангах зорилгоор дотоод хяналтыг зохион байгуулах	Тогтмол хэрэгжиж байна	Дотоод хяналтын хэлтэс хяналт тавин ажилладаг
2	Байгаль орчны аудит хийлгэх	15,000,000	Тендерийн шатанд явж байна
3	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоох	Хэрэгжиж байна	Байгаль орчны үйл ажиллганы журам боловсруулагдсан, удирдлагуудаар хэлэлцүүлэгдэхээр хүлээгдэж байна
4	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилтан, ажилчдын дунд сургалт семинарыг хагас жилд нэг удаа тогтмол зохион байгуулах	Тогтмол хэрэгжиж байна	ХАБ-н бүх ажилчидын давтан сургалтын агуулгад багтсан
5	Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллах, үйлчлүүлэх талаар тохиролцох, үйлдвэрлэлийн онцлогтой холбогдон гарч болзошгүй өвчлөл, гэмтэл, хордлогын талаар мэдээлэл харилцан солилцож, зохих бэлтгэлийг хангах	Тухай бүр хэрэгжинэ	Аюул ослын үед хамтран ажиллана.

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Д/д	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хэрэгжилт	Тайлбар
1	Дархан-Уул аймгийн БОАЖ-ын газарт	Хурал	Уурхайн үйл ажиллагаа, 2022 оны БОМТ-ний хэрэгжилт	Дархан-Уул аймгийн БОАЖГ азарт тайлагнасан	-
2	Орон нутгийн иргэдэд	Өдөрлөг	Уурхайн үйл ажиллагаа, 2022 оны БОМТ-ний хэрэгжилт, хамтран ажиллах боломжийн талаар сурталчлах	Төлөвлөж байна	-

13. Дүгнэлт

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт ажлыг 159,466,255 төгрөгийн төсвөөр бүрэн дүүрэн хийж гүйцэтгэсэн байна.

Д/д	Зардлын төрөл	Дүн /сая төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	24.8
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	31.2
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	15.1
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	Дотоод зардал
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	1.47
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	0.55
9	Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	71.3
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	15
Нийт		159.4

14. Хавсралт

1. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэмжилт, дээжлэлт хийж буй агшны гэрэл зураг
4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүн
5. Хайгуулын ажил, ТЭЗҮ -г хүлээн авсан тушаал, тэмдэглэл
6. БОХ-3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ
7. Нөөц ашигласны төлбөр тушаасан баримтын хуулбар
8. Нөөцийн хөдөлгөөний тайлангийн хуулбар
9. Хилээр экспортод гаргасан бүтээгдэхүүний талаар гаалийн албанаас гаргасан мэдээ
10. Газрын төлбөр төлсөн баримт

Жич: Хавсралтыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3 дугаар хавсралтыг үндэслэн боловсруулсан. Мөн уг хавсралтаас дээр дурьдагдсан болон уурхайн үйл ажиллагаатай холбоогүй хавсралтуудыг хассан болно.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

